



СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.05.31. №65 (65)

ҮЙЛ ЯВДАЛ



МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧИНД “ЧИНГИС ХААН” ОДОН ХҮРТЭЭВ

Монгол Улсад орчин үеийн Зэвсэгт хүчин байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга зарлиг гаргаж, Монгол Улсын төрийн дээд шагнал, тэргүүн зэргийн “Чингис хаан” одонг Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүнд хүртээлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигт “... Өнгөрсөн түүхийн туршид Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, газар нутгийн халдашгүй дархан байдлыг сахин хамгаалах, Их эзэн Чингис хааны ялагдашгүй цэргийн залгамж

Монгол цэргийн нэр төр яруу алдрыг өндөрт өргөж, дэлхий нийтийн аюулгүй байдлыг хангах үйлсэд эр зориг тэсвэр тэвчээр, сахилга бат, ур чадвараар манлайлан оролцож, эх орон, төр ард түмнийхээ өмнө өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэсэн, Зэвсэгт хүчний үеийн ажилтан, албан хаагч, цэрэг, офицер, ахлагчдын гарамгай гавьяа зүтгэлийг өндрөөр үнэлж, Монгол Улсын Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүнийг Монгол Улсын төрийн дээд шагнал, тэргүүн зэргийн одон – “Чингис Хаан” одонгоор шагнасугай” гэжээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу Монгол Улсын төрийн дээд шагнал, тэргүүн зэргийн “Чингис хаан” одонг хүртээх ёслолын үйл ажиллагаа өнгөрсөн бямба гарагт төв талбайд боллоо. “Чингис хаан” одонг Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүнийг төлөөлүүлэн Зэвсэгт хүчний Жанжин штабт гардуулав. Ташрамд дурдахад, Монгол Улсын төрийн дээд шагнал, тэргүүн зэргийн “Чингис хаан” одонг байгууллага, хамт олноороо гардан авсан нь Монгол Улсын Зэвсэгт хүчин болж байна.

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Г.САЙХАНБАЯР ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 065 ДУГААР АНГИД АЖИЛЛАЛАА



Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Зэвсэгт хүчний 065 дугаар ангид 2021 оны 5 дугаар сарын 28-ны өдөр ажиллалаа. Батлан хамгаалахын сайдыг Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн Хүндэт харуул ёслол төгөлдөр угтан авсны дараа ангийн танилцуулгыг сонсож, сүүлийн жилүүдэд хийж хэрэгжүүлсэн томоохон ажил, цэргийн сургалт бэлтгэл, штабын бэлтгэлжилт болон тулгамдаж буй асуудлыг нь сонссон юм.

Үүний дараа тэрээр бие бүрэлдэхүүнд батлан хамгаалах салбарын хэмжээнд хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээний талаар мэдээлэл өгч, тодорхой асуудлаар үүрэг, чиглэл өгөөд зарим алба хаагчийг шагнаж урамшуулсан юм. Үүнд, Дайчин алдар-I медиалаар дэд хурандаа Н.Гантулга, хошууч, Д.Буянбаатар нарыг, Дайчин алдар-II медиалаар ахлах ахлагч Ц.Галмөнх, ахмад, Ө.Энхсаруул, Эх орны төлөө-III хүндэт тэмдгээр дэслэгч Э.Санчир нар тус тус шагнагдсан юм. Батлан хамгаалахын сайдыг дагалдаж БХЯ-ны СБТГ-ын дарга, хурандаа С.Ганбямба, ХШУДАГ-ын дарга, хурандаа Б.Эрхэмбаяр, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч, хошууч генерал О.Энхбаяр болон албаны бусад хүмүүс байлцлаа.

ЦЭРГИЙН ЁСЛОЛЫН ЖАГСААЛААР АЛХАЖ, ЁСЛОЛЫН БУУДЛАГА ХИЙЛЭЭ



“Олон улсын энхийг сахиулагчийн өдөр”-ийг тохиолдуулан ЗХЖШ, Төрлийн цэргийн командлалууд, Улаанбаатар цэргийн хүрээний нэгтгэл, ангиуд жанжин Д.Сүхбаатарын талбайд цэргийн ёслолын жагсаалаар алхаж, Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн алба хаагчид ёслолын буудлага хийлээ. Цэргийн ёслолын арга хэмжээнд төр, засгийн удирдлагаас гадна НҮБ-ын Монгол дахь суурин төлөөлөгч Тапан Мишра, Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдууд, БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлалын удирдлагууд оролцлоо.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
8	-4

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
37	23

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
31	16

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.844.00	2.855.00
EUR	3.420.00	3.525.00
CNY	445.50	449.90
RUB	37.90	40.10
JPY	25.45	26.32
KRW	2.44	2.63

ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 20
2021.05.31.
/БААСАН ГАРАГ/

ЗУНЫ ТЭРГҮҮН ХАРАГЧИН МОГОЙ САРЫН НЭГ ЦАГААН ШАРАГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Үс засуулбал:

Өлсөж ундаасна.

Наран ургах, шингэх:

04.58-20.42

Барилдлага:

Идэр

Шүтэн барилдлага:

Хуран үйлдэхүй

Суудал:

Хий

Аргын тооллын 5 сарын 31, Сумъяа гараг. Билгийн тооллын 20, Яруу эгшигт одтой, шарагчин туулай өдөр. Өдрийн наран 4 цаг 58 минутад мандан, 20 цаг 42 минутад жаргана. Тухайн өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, угаал үйлдэх, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, хийморийн дарцаг хатгахад сайн. Газар хагалах, ус булгийн эх малтах, уул овоо тахихад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үрээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН

57.512

ЭДГЭРСЭН

49.754

НАС БАРСАН

272/14

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

2563 (34)

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

260

ЭДГЭРСЭН

2267

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 169,118,995

Эдгэрсэн

Нийт: 154,881,941

Нас барсан

Нийт: 3,519,175

ТАНДАЛТ

ВАКЦИНЖУУЛАЛТАД ХАМРАГДСАН СҮҮЛИЙН 24 ЦАГТ	НИЙТ 63,449	3,027,240
ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭ /ПГУ/ СҮҮЛИЙН 24 ЦАГТ	НИЙТ 7,837	2,933,544
ХУРДАВЧИЛСАН ОНОШИЛГОО СҮҮЛИЙН 24 ЦАГТ	НИЙТ 855	424,615
ТУСГААРЛАЛТАД БАЙГАА ХҮН СҮҮЛИЙН 24 ЦАГТ	НИЙТ 636	83,003

2021.05.30
11:00 ЦАХИМ БАЙДЛААР



ҮЙЛ ЯВДАЛ

"МОНГОЛ ЦЭРЭГ-ДЭЛХИЙН ЦЭРЭГ" ХЭМЭЭХ ӨГҮҮЛЭМЖЭЭР БӨМБӨРЦӨГ БҮТЭЭЖЭЭ



"Олон улсын энхийг сахиулагчийн өдөр"-ийг тохиолдуулан Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд болсон өөр нэг арга хэмжээ нь хүүхэд, залууст Монгол Улсын Зэвсэгт хүчний энхийг сахиулах үйлсэд оруулж буй хувь нэмрийг сурталчлах, энхийг сахиулагчдын амжилт бүтээл, гавьяа, зүтгэлийг алдаршуулах хүрээнд "Дурсгалын хөшөөний бөмбөрцөг"-ийг шинээр бүтээж, жагсаалын талбайг байгуулсан явдал байв. Бүтээн байгуулалтын нээлтийн ёслолын ажиллагаанд ЗХЖШ-ын ахлагч, тэргүүн ахлагч Б.Гантөмөр, ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын генерал С.Дашзэвэг, Батлан хамгаалах яамны Гадаад

хамтын ажиллагааны газрын дарга хурандаа Б.Бат-Эрдэнэ, "Рагчаа сан"-гийн тэргүүн Р.Эрдэнэбилэг, Монгол Улс дахь НҮБ-ын суурин зохицуулагчийн газрын, стратеги төлөвлөлт хариуцсан ажилтан Ж.Должинсүрэн нарын БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлалын удирдлага, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын алба хаагчид оролцов.

Энэхүү дурсгалын хөшөө нь эр зориг, тэсвэр хатуужлаараа онцгойрон шалгарч дэлхийн халуун цэгт энхийг сахиулах үүргээ нэр төртэй гүйцэтгэж, энхийн төлөө хувь нэмрээ оруулсан дайчдын тухай өгүүлэх бүтээн байгуулалт юм.

Тус арга хэмжээний үеэр

цэргийн ажиглагч, штабын офицероор үүрэг гүйцэтгэсэн бүрэлдэхүүнд шагнал гардуулах ёслол болов. Үргэлжлүүлээд уламжлал болсон шагнал буюу "Рагчаа сан"-аас Зэвсэгт хүчний шилдэг энхийг сахиулагчдад олгогддог өргөмжлөл эзэддээ очлоо. "Шилдэг энхийг сахиулагч офицер"-оор ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын Энхийг дэмжих ажиллагааны хэлтсийн дарга, хурандаа Т.Буянбат, "Шилдэг энхийг сахиулагч ахлагч"-аар ахлагч Д.Чинбат (330), "Шилдэг эмэгтэй энхийг сахиулагч"-аар ахлах ахлагч Л.Цэрэндэжид (065) нар шалгарсныг "Рагчаа сан"-гийн тэргүүн Р.Эрдэнэбилэг гардуулан өгч, баяр хүргэсэн юм.

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНААС ХУРАНДАА Н.НЯМЖАРГАЛД ТАЛАРХАЛ ДЭВШҮҮЛЛЭЭ

Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг өнгөрсөн баасан гарагт ЗХЖШ-ын Цэргийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга, хурандаа Н.Нямжаргалыг хүлээн авч уулзаж, талархал дэвшүүлээ. Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг "Олон улсын энхийг сахиулагчийн өдөр"-ийг тохиолдуулан Монгол Улсын эмэгтэй цэргийн алба хаагчдын энхийг сахиулах зам мөрийг гаргасан эрхэм танд баяр хүргэе. Таны гаргасан зам мөрөөр өнөөдөр давхардсан тоогоор 800 гаруй эмэгтэй цэргийн алба хаагч энхийг сахиулж, дэлхий дахинд энх тайван, тогтвортой байдлыг сахин хамгаалах үүргийг нэр төртэй гүйцэтгэж байна. Олон орны цэрэг дайчидтай мөр зэрэгцэн олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах үйлсэд хүчин зүтгэж буй нийт энхийг сахиулагчдаар Монголын ард түмэн ямагт бахархдаг.



Та бүхний зүтгэлийг НҮБ-ын удирдлага өндөрөөр үнэлж, энхийг сахиулах бүх хүчинд үлгэр дуураллал болохуйц өндөр жишиг тогтоосон хамгийн зоригтой, эрэлхэг, шийдэмгий хэмээн тодорхойлсон нь манай цэрэг дайчдын ур чадварыг дүгнэсэн томоохон үнэлгээ гэж үзэж байна" хэмээгээд Гадаад хэргийн яамны "Жуух бичиг"-ийг гардуулан өгсөн юм.

Хурандаа Н.Нямжаргал нь 2006 онд ахмад цолтой байхдаа Монгол Улсаас НҮБ-ын энхийг дэмжих ажиллагааны Баруун Сахар дахь MINURSO ажиллагаанд цэргийн ажиглагчаар үүргээ нэр төртэй гүйцэтгэсэн юм. Монгол Улс өдгөө НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд эмэгтэй цэргийн алба хаагч илгээсэн 112 улсаас 17 дугаарт эрэмбэлэгдэж байна.

ЧУУЛГЫН ЭНХИЙН САХИУЛАГЧИД АЯНЫ БОГЦОО ЗАДАЛЛАА



ЦДБЭЧ

Даян дэлхийд энхийг сахиулагчдын өдрийг тохиолдуулан ЦДБЭЧ-аас БНӨСҮ-д явагдаж буй НҮБ-ын мандаттай энхийг сахиулах "UNMISS" ажиллагаа болон Исламын Бүгд Найрамдах

Афганистан улсад НАТО-гийн тэргүүлдэг "Шийдвэртэй дэмжлэг" ажиллагаанд үүргээ амжилттай гүйцэтгээд ирсэн дэд хурандаа А.Дондов, ахлах ахлагч Г.Ганцогт, Н.Мөнгөн-Очир, ахлагч Б.Мягмардорж, Д.Өлзийбаяр, Б.Пунцагдаш нар маань аян замын үүцээ задалж,

уран бүтээлийн дээдээр сонорыг мялааж, энхийг сахиулах ажиллагаа, газар орны байдал, манай цэнхэр дуулгатнуудын хийморьлог үйлсээр мэлхийг цэнгүүлээ.

Энх и й г с а х и у л а г ч д а а р а а бахархах чуулгын хамт олон нь хөгжимчин Д.Өлзийбаярхнаа анхны шинэ уран бүтээлийг хамтдаа сонсч, басхүү дуулдаг нууцхан авьяасыг олж харсандаа олзуурхав.

Энэ үеэр ЦДБЭЧ-ын дарга, Соёлын төв өргөөний Ерөнхий менежер, хурандаа Г.Золзаяа "Намайг ирэхэд тасаг хүрэхгүй байсан энхийг сахиулагчид маань одоо салааны дайтай болжээ" гэж бахархангуй хэлж байлаа. Өнөөдрийн байдлаар энхийг сахиулаад ирсэн чуулгын цэнхэр дуулгатны тоо хэдий нь 20 гарчээ.

"ЭНХИЙН ТӨЛӨӨ-ЭРҮҮЛ АМЬДРАЛ"



"Олон улсын энхийг сахиулагчдын өдөр"-ийг тохиолдуулан "Энхийн төлөө-эрүүл амьдрал" уриан дор гүйлтийн тэмцээнийг өнгөрсөн баасан гарагт зохион байгууллаа.

Гүйлтийн тэмцээнд Улаанбаатар цэргийн хүрээний 300 гаруй баг, тамирчин оролцож, хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж, "Энхийн төлөө-эрүүл амьдрал"-ыг эрхэмлэж буйгаа онцлов.

Тэмцээний нээлтийн арга хэмжээнд БХЯ-ны Гадаад хамтын ажиллагааны

газрын дарга, хурандаа Б.Бат-Эрдэнэ, нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа Ц.Анхбаяр, Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн командлагч, бригадын генерал Б.Баатар, ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын Энхийг дэмжих ажиллагааны хэлтсийн дарга, хурандаа Т.Буянбат нарын албаныхан оролцсон юм. Бригадын генерал Б.Баатар тэмцээнийг нээж хэлсэн үгэндээ "НҮБ-аас "Олон улсын энхийг сахиулагчдын өдөр" болгон зарласан энэ өдрийг Монгол Улсын Зэвсэгт

хүчин цэрэг хандивлагч орны хувьд 2005 оноос хойш ёслол төгөлдөр тэмдэглэж ирсэн. Дэлхийн энхийн үйлсэд үнэтэй хувь нэмрээ оруулсан энхийг сахиулагчдын хувьд энэ өдрийг "Энхийн төлөө-эрүүл амьдрал" уриатайгаар гүйлтийн тэмцээнийг хамтдаа зохион байгуулж байна" хэмээгээд баг, тамирчдад амжилт хүссэн юм.

Тэмцээнд эрэгтэй цэргийн алба хаагчид насны ангиллаар 5-10 км, эмэгтэй эмэгтэй цэргийн алба хаагчид 5 км зайд уралдаж, шилдгүүдээ тодруулсан юм.

Зэвсэгт хүчний 065 дугаар анги

ТҮВШИН ТОГТООХ ҮЗЛЭГТ БЭЛТГЭЛ АЖЛЫГ БҮРЭН ХАНГАХААР ОФИЦЕР, АХЛАГЧИЙН БЭЛТГЭЛЖИЛТИЙГ ШАЛГАЛАА

Зэвсэгт хүчний офицер, ахлагч нарын түвшин тогтоох үзлэгийг энэ сарын 24-ний өдрөөс эхлэн зохион байгуулж явуулахтай холбоотойгоор ангийн удирдлага бие бүрэлдэхүүний хувийн бэлтгэлийг шалгаж тодорхой үүрэг, чиглэл өглөө.


Түвшин тогтоох үзлэг нь ажлын гүйцэтгэл, үрдүн, албаны хандлага, мэргэжлийн түвшин, сахилга, ёс зүйн төлөвшил, бие бялдрын бэлтгэлжилт, эрүүл мэндийн байдал, сэтгэл зүйн байдал зэрэг таван чиглэлийн хүрээнд явагдана. Үзлэг нь офицер, ахлагчийн мэргэшил, ур чадвар, албан тушаалын гүйцэтгэл, сахилга хариуцлага, ёс зүйн хэм хэмжээ, эрүүл



мэндийн зэрэглэл, бие бялдр болон сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшин тогтоох, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж,

цэргийн алба хаагчдын ёс зүйн төлөвшил, албандаа хандах хандлага, нийгэмд эзлэх байр суурь, манлайллыг нэмэгдүүлэх зорилготой юм.

ХОГГҮЙ ДҮҮРЭГ БОЛГОЁ



Б а я н з ү р х дүүргийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулж буй "Хоггүй дүүрэг болгоё" их цэвэрлэгээний хүрээнд өнгөрсөн долоо хоногт ангийн

бие бүрэлдэхүүн хамрагдаж автобусны буудал болон 24 дүгээр хорооны ойр орчны цэвэрлэгээг амжилттай хийж дуусгалаа.

Ахмад Ө.ЭНХСАРУУЛ